



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/158/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.2 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Тод.од. 18

№ 2/52

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\A4.docx


005020330

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The signature is stylized and appears to be 'B. Mönkhbat'. The stamp contains some illegible text in Mongolian script.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,569,577.00	88,175,017.00
33	АВЛАГА	427,133.00	427,133.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	427,133.00	427,133.00
35	БАРАА МАТЕРИАЛ	86,142,444.00	87,747,884.00
351	Түүхий эд материал	6,099,190.00	6,099,190.00
35110	Тусгай зориулалттай материал	6,099,190.00	6,099,190.00
354	Хангамжийн материал	80,043,254.00	81,648,694.00
35410	Бичиг хэргийн материал	411,100.00	92,100.00
35420	Аж ахуйн материал	5,103,100.00	5,103,100.00
35450	Барилгын засварын материал	240,000.00	240,000.00
35470	Бусад хангамжийн материал	74,289,054.00	76,213,494.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,488,990.69	35,924,751.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,488,990.69	35,924,751.84
392	Биет хөрөнгө	23,727,890.69	30,163,651.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	9,791,666.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-815,972.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	90,607,251.00	96,096,551.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-85,731,421.05	-87,261,562.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,149,396.00	111,149,396.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-94,091,135.26	-100,551,826.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,474,500.00	2,474,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,365,700.00	-1,524,100.00
39217	Ном	685,000.00	805,000.00
393	Биет бус хөрөнгө	3,761,100.00	5,761,100.00
39301	Программ хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,761,100.00	5,761,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	114,058,567.69	124,099,768.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	5,746,805.13
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	5,746,805.13
413	Өглөг	00.00	5,746,805.13
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	5,746,805.13
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	114,058,567.69	118,352,963.71
51	Засгийн газрын хувь оролцоо	114,058,567.69	118,352,963.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	137,949,437.69	137,949,437.69
51101	Өмч: - төрийн	137,949,437.69	137,949,437.69
512	Хуримтлагдсан үр дүн	-46,992,231.00	-42,697,834.98
51210	Өмнөх үеийн үр дүн	-46,992,231.00	-46,992,231.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,294,396.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	23,101,361.00	23,101,361.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	114,058,567.69	124,099,768.84




Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	473,833,900.00	475,829,376.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	980,000.00	9,791,666.00
120	Нийтлэг татварын бус орлого	980,000.00	9,791,666.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	980,000.00	9,791,666.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	980,000.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	9,791,666.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,853,900.00	466,037,710.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,164,000.00	5,721,310.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,164,000.00	5,721,310.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	434,689,900.00	460,316,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,689,900.00	460,316,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	468,228,573.15	471,534,979.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,228,573.15	471,534,979.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462,893,509.13	434,653,359.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,420,665.00	288,657,055.00
210101	Үндсэн цалин	278,420,665.00	288,657,055.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,078,158.98	36,900,850.13
210201	Тэтгэврийн даатгал	34,078,158.98	36,900,850.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,058,392.00	78,750,749.00
210301	Гэрэл, цахилгаан	1,626,556.00	1,882,591.00
210302	Түлш, халаалт	71,753,220.00	70,796,510.00
210303	Цэвэр, бохир ус	6,678,616.00	6,071,648.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,931,068.00	6,213,151.00
210401	Бичиг хэрэг	1,256,890.00	1,830,060.00
210402	Тээвэр, шатахуун	4,009,538.00	2,618,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	421,600.00	512,431.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	255,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	988,040.00	952,660.00
2105	Нормативт зардал	00.00	450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,618,360.00	2,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	00.00
210604	Урсгал засвар	4,518,360.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,067,400.00	999,000.00
210702	Дотоод албан томилолт	2,067,400.00	999,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,067,485.00	4,248,400.00



Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,526,185.00	3,700,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	198,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	241,300.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,651,980.15	16,434,154.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	7,468,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,651,980.15	8,965,204.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,335,064.02	36,881,620.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	36,019,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	35,019,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,835,064.02	862,320.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,823,729.02	841,010.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	11,335.00	21,310.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,605,326.85	4,294,396.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,605,326.85	4,294,396.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	472,853,900.00	466,037,710.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,853,900.00	466,037,710.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,164,000.00	5,721,310.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,164,000.00	5,721,310.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	434,689,900.00	460,316,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,689,900.00	460,316,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	461,651,100.00	458,428,410.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,651,100.00	458,428,410.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,316,035.98	421,546,790.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,772,000.00	281,772,000.00
210101	Үндсэн цалин	281,772,000.00	281,772,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,027,535.98	38,039,100.00
210201	Тэтгэврийн даатгал	25,076,862.23	26,768,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,798,563.59	2,817,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,086,821.34	2,254,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	551,685.40	563,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,513,603.42	5,635,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,058,392.00	78,750,749.00
210301	Гэрэл, цахилгаан	1,626,556.00	1,330,623.00
210302	Түлш, халаалт	71,753,220.00	70,796,510.00



Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	6,678,616.00	6,623,616.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,319,913.00	5,897,691.00
210401	Бичиг хэрэг	1,543,550.00	1,544,060.00
210402	Тээвэр, шатахуун	4,017,998.00	2,618,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	421,600.00	479,431.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	986,765.00	956,200.00
2105	Нормативт зардал	540,000.00	450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	540,000.00	450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,568,500.00	2,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	00.00
210604	Урсгал засвар	4,468,500.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,067,400.00	999,000.00
210702	Дотоод албан томилолт	2,067,400.00	999,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,962,295.00	4,248,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,420,995.00	3,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	198,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	241,300.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	9,390,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	9,390,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,335,064.02	36,881,620.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	36,019,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	35,019,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,835,064.02	862,320.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,823,729.02	841,010.00
213404	Хөрөнгийн	11,335.00	21,310.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,202,800.00	7,609,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,202,800.00	7,609,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,202,800.00	7,609,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,202,800.00	7,609,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,202,800.00	7,609,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11,202,800.00	-7,609,300.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00



Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-52,597,557.85	108,453,240.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-52,597,557.85	108,453,240.84
C07	Тайлант үеийн үр дүн	0	0	5,605,326.85	5,605,326.85
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-46,992,231.00	114,058,567.69
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-46,992,231.00	114,058,567.69
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-46,992,231.00	114,058,567.69
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	4,294,396.02	4,294,396.02
D09	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	137,949,437.69	23,101,361.00	-42,697,834.98	118,352,963.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	460,316,400.00	459,475,390.00	841,010.00	99.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	460,316,400.00	459,475,390.00	841,010.00	99.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,297,100.00	423,456,090.00	841,010.00	99.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,772,000.00	281,772,000.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	281,772,000.00	281,772,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,039,100.00	38,039,100.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	26,768,300.00	26,768,300.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,817,700.00	2,817,700.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,254,200.00	2,254,200.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	563,500.00	563,500.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,635,400.00	5,635,400.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,518,400.00	78,750,749.00	767,651.00	99.03
210301	Гэрэл, цахилгаан	1,900,000.00	1,330,623.00	569,377.00	70.03
210302	Түлш, халаалт	70,815,800.00	70,796,510.00	19,290.00	99.97
210303	Цэвэр, бохир ус	6,802,600.00	6,623,616.00	178,984.00	97.37
2104	Хангамж, бараа материалын зардал	5,902,400.00	5,897,691.00	4,709.00	99.92
210401	Бичиг хэрэг	1,544,200.00	1,544,060.00	140.00	99.99
210402	Тээвэр, шатахуун	2,618,000.00	2,618,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	484,000.00	479,431.00	4,569.00	99.06
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	956,200.00	956,200.00	0.00	100.00



Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	450,000.00	450,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	450,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	999,000.00	1,000.00	99.90
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	999,000.00	1,000.00	99.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	615,200.00	548,000.00	67,200.00	89.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	265,200.00	198,000.00	67,200.00	74.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,999,550.00	450.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,999,550.00	450.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36019300.00	36019300.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,019,300.00	36,019,300.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,019,300.00	35,019,300.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	460,316,400.00	459,475,390.00	841,010.00	99.82
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	460,316,400.00	459,475,390.00	841,010.00	99.82
132001	Орон нутгийн төсвөөс	460,316,400.00	459,475,390.00	841,010.00	99.82
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.00	26.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	18.00	-1.00	105.88
620003	Үйлчлэх ажилтан	08.00	07.00	1.00	87.50
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00	0.00	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	18.00	18.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	08.00	08.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,164,000.00	5,700,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,164,000.00	5,700,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,164,000.00	5,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,164,000.00	5,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,164,000.00	5,700,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	38,164,000.00	5,700,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,164,000.00	5,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,164,000.00	5,700,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд 2021.01.01-2021.06.23 хүртэл Б.Ганчимэг, 2021.06.24-эхлэн Ж.Батболд нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч У.Дагийран 2021.01.01-нээс 2021.08.31 хүртэл, М.Мөнхбат 2021.09.01-2021.12.31-ны хооронд хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургалт, уран бүтээлийн үйл ажиллагаа явуулах. Байгууллагын зорилт: Мэргэжлийн чадварлаг боловсон хүчинтэй, чанартай үйлчилгээ таатай орчин, технологийн шинэчлэлтэд тулгуурлаж үзэгчид, суралцагч хүүхдүүдийн эрэлт хэрэгцээг хангаж хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх мэргэжлийн чиг баримжаа олгож тэдэнд урлагийн боловсролоор дамжуулан хүүхдийн бахархалт бүтээлийг бий болгох, орчин үеийн болон сонгодог ардын өв соёл биет болон биет бус өвийг сэргээн өвлүүлэх уран бүтээлийг нийтэд түгээх дэлгэрүүлэх” гэсэн зорилготой ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 468,228.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,682.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,277.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3,300.7 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 124,099.7 мянган төгрөг болж өмнөх оноос 10,041.2 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,569.50	88,175.00	1,605.50
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	427.10	427.10	0.00
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	86,142.40	87,747.80	1,605.40
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,488.90	35,924.70	8,435.80
Үндсэн хөрөнгө	209,227.20	226,628.20	17,401.00
Хуримтлагдсан элэгдэл	-181,738.20	-190,703.40	-8,965.20
Нийт хөрөнгө	114,058.50	124,099.70	10,041.20
Өр төлбөр	00.00	5,746.80	5,746.80
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	114,058.50	118,352.90	4,294.40
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	114,058.50	124,099.70	10,041.20

Бараа материалын дансны үлдэгдэл 87,747.8 мянган төгрөг болж 1,605.4 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл өмнөх оноос 1,924.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 226,628.1 мянган төгрөг болж 17,401.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5,489.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 120.0 мянган төгрөгийн ном, 2,000.0 мянган төгрөгийн "Сүүлчийн хавар" драмын жүжиг нийт 17,400.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу холбогдох дансанд бүртгэсэн мөн аймгийн ИТХ-ын 2021 оны 09 сарын 06 өдрийн 96 дугаар тогтоолоор 9,791.6 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг Биеийн тамир спортын газраас шилжүүлэн авсныг тус тус холбогдох дансанд орлогоор бүртгэсэнтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 118,352.9 мянган төгрөг болж 4,294.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 4,294.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 587,147.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 125,992.9 мянган төгрөгөөр бууруулж 461,154.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 460,316.4 мянган төгрөг болж 838.3 мянган төгрөг буюу 0.1 хувиар өсөж батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 460,316.4 мянган төгрөгийн төсөв баталж орон нутгийн төсвөөс 460,316.4 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 460,316.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 459,475.3 мянган төгрөгийг зарцуулж 841.0 мянган төгрөг буюу 0.1 хувийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 459,475.3 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай тогтмол зардлыг 767.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 67,2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100030035405 тоот дансанд дугуйлангийн сурагчдын сургалтын төлбөр 4,219.5 мянга, Өсвөр үе, залуу гэр бүлүүдэд урлагаар дамжуулах соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн ажлын санхүүжилт 1,000.0 мянган төгрөг орж ирснийг Уран жиргээ уралдааны зардал 2,721.3 мянга, Уран бүтээлийн зардалд 2,000.0 мянга, Бүжгийн багшийн сургалтын төлбөрт 1,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Соёлын ажилтнуудын онцлогийг харуулсан "Мэргэжил бүхэн сайхан" нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд сурталчилсан. Аавдаа захидал бичээрэй контент 10, Моно жүжиг 8, сэргээн тавьсан жүжиг 3, бие даасан уран зургийн "Монгол дал" үзэсгэлэн, уран жиргээ 2021, сэтгэлийн нартай нутаг уран зургийн уралдаан, дуулах өв, Орчин үеийн дуу бүжгийн өвлийн халз тулаан зэрэг тэмцээн уралдаан зохион байгуулсан.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 24 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 92%-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 471,534.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 3,306.4 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамжийн материал өмнөх оноос буурсан бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 460,316.4 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулахаас 188,109.2 мянган төгрөгийн мэдээлэл зэрэг 68 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	4	5	2
2	Хагас жил	4	4	3	1	0
3	Улирал бүр	1	4	3	1	0
4	Сар бүр	3	36	21	15	0
5	Тухай бүр	8	96	50	46	0
	Нийт	27	151	81	68	2

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Урсгал төсвийн зарцуулалт нь гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 460,316.4 мянга мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 459,475.3 мянган төгрөгийг зарцуулж 841.0 мянган төгрөг буюу 0.1 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд тогтмол зардалд 79,518.4 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 15,903.6 мянган төгрөг байна. Тус онд 15,136.0 мянган төгрөгийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,097.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 497.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,600.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж хэрэгжилтийн тайланг 2021 оны 06 дүгээр сарын 14-ны өдрийн 53 тоот албан бичгээр ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аяны хүрээнд шалгасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласантай холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр үүссэн байна. Дараагийн аудитаар батлагдсан орон тоог баримтлан ажиллаж байгаа эсэх талаар анхаарч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 8,193.8 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс 2,000.0 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулан, санхүүгийн аудитын 6,193.8 мянга, шилэн дансны 188,109.2 мянга, Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн 15,136.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Залруулга

4.1.1 Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 2,000.0 төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 6.1 “Тайлангийн хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд үзүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайлангийн Мөнгөн гүйлгээний тайланд 2000,0 мянган төгрөгийг зардал хооронд залруулав.

4.2 Зөвлөмж

4.2.1 Шатахууны зардалд 2618.0 мянган төгрөг зарцуулсан боловч замын хуудас бичээгүй, 447.0 мянган төгрөгийн шатахууны анхан шатны баримт дутуу замын хуудсыг бүрэн хаагаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн “13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв

гаргах үндэслэл болно”, “13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн нь санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид холбогдох хууль журмын дагуу анхан шатны баримтад тулгуурлан ажил гүйлгээг бүртгэж, баримтын бүрдлийг хангаж ажиллах.

4.2.2 Нярав бараа материалын тайланг сар бүр гаргадаггүй 12 дугаар сард өссөн дүнгээр гаргаж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.2.тасралтгүй байх; 5.1.4.үнэн зөв байх; гэсэн заалтыг тус тус зөрчсөн нь “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид холбогдох хууль журмын дагуу анхан шатны баримтад тулгуурлан ажил гүйлгээг бүртгэж тайлагнаж байх.

4.2.3 Батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллаж 5746.8 мянган төгрөгийн НДШ-н өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйл “16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид батлагдсан орон тоо баримтлан, тайлант оны цалингийн санд багтаан ажил үйлчилгээг явуулах.

4.2.4 Тайлант онд тогтмол зардалд 79,518.4 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 15,903.6 мянган төгрөг байна. Тус онд 767.6 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 15,136.0 мянган төгрөгийн хэмнэлтийг үүсгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Цаашид Засгийн газрын тогтоол болон дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн ажиллах.

4.2.5 Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн системд нийт 460,316.4 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулахаас 188,109.2 мянган төгрөгийн мэдээлэл зэрэг 68 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5 дахь заалтыг тус тус зөрчсөн нь “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.4, 6.4.5 дахь хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	4	8,193.8	1	2,000.0	0	0	0	0	3	6,193.8
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	2	203,245.2	0	0	0	0	0	0	2	203,245.2
	Дүн										
	НИЙТ ДҮН	6	211.439	0	0	0	0	1	0	1	203,245.2

_____оОо_____

